

ОЮУНЫ ЭРДЭМ ШИНЖИЛЭЭНИЙ АЖИЛ

Терроризмын мөн чанар, түүнд хийх дүгнэлт

XX зууны эцэс XXI зууны эхэн үед дэлхий нийтийн амьдралд гүнзгий өөрчлөлт гарч дэлхийн улс орнууд улам бүр даяарчлагдаж хамтын хүч чармайлтаар шийдвэрлэх тулгамдсан олон асуудал гарч байна. хамтын хүчээр шийдвэрлэвэл зохих асуудлуудын нэгэнд Олон Улсын гэмт хэргийн нэгэн хэлбэр болох терроризм түүнтэй тэмцэх асуудал зүй ёсоор орох боллоо.

Иймд терроризм гэж юу вэ? Түүний хор хөнөөл, Монголд даяарчлалын замаар терроризм нөлөөлөх магадлал, үр дагаврын талаар санал бодлоо илэрхийлэхийг зорив.

Хүмүүсийг утга учиргүй хөнөөж, улс гүрнүүд тэдгээрийн төлөөлөгчдийн хэвийн үйл ажиллагааг тасалдуулан улс хоорондын зам харилцааг саатуулж хүндрэл учруулдаг олон улс дамнасан зохион байгуулалттай гэмт үйлдлийг терроризм буюу олон улсын гэмт хэрэг гэж нэрлэж заншжээ. Энэ хэргийг харгис бүлэглэл, нам шашинд итгэгч зарим хүмүүс, гэмт хэргийн байгууллагаас явуулах нь их байдаг. Хууль бус ямар үйл ажиллагаа хийсэн тохиолдолд олон улсын шинжтэй терроризм хэрэг гэж үзэх вэ ?

- гэмт хэрэгтэн хохирогч хоёр ба түүнээс дээш гүрний иргэд боловч гэмт хэргийг эдгээр орны хилийн чанадаас үйлдсэн бол

- Олон улсын хамгаалалтад байдаг этгээдийн эсрэг алан хядах ажиллагаа үйлдсэн бол

- Гэмт хэргийг нэг орны нутаг дэвсгэр дээр үйлдээд нөгөө улсад гүйцэтгэсэн бол

- Алан хядагч нэг гүрэнд хядлага үйлдээд нөгшөө улсад нуугдсанаар түүнийг шилжүүлэн өгөх тухай асуудал гарсан зэрэг

олон шинж чанар бүхий үйлдлийг террорист үйл ажиллагаа гэж үзэж болохыг судлаач Д.Мөнхтуяа “Эрүүгийн эрх зүй” номондоо тодорхойлжээ.

Өнөөдөр дэлхий дээр 5000 орчим хэт даврагч алан хядагч янз бүрийн байгууллага бүлэглэл ажиллаж байна гэдгийг судлаачид тогтоожээ. Сүүлийн үеийн алан хядах үйл ажиллагаа нь зөвхөн төрийн эсрэг биш эдийн засгийн шинжтэй болж сүрдүүлэг үзүүлж их хэмжээний мөнгө дээрмийн аргаар авах явдал нэмэгдэж байна. Халдлагын объектын хувьд олон улсын хамгаалалтад байх хүмүүсээс гадна жирийн иргэдийг барьцаалах боллоо.

Терроризмын сүүлийн үеийн тод жишээ нь дэлхийн худалдааны төв гэгддэг 110 давхар хос байшинг санаатайгаар буюу харгис аргаар сүйтгэсэн аймшигт үйл ажиллагаа юм.

Энэ худалдааны төвд өдөрт ойролцоогоор 50-100 мянган хүн ажиллаж үйлчлүүлдэг байжээ. Энэ аллагад сүүлийн баримтаар 97 орны 5000-аад хүн хорлогдсон нь тодорхой болоод байна.

Энэхүү террорист хэргийг амьдралынхаа гол зорилгыг америкийн эсрэг тэмцэх явдал хэмээн тодорхойлсон Саудын Арабын саятан Осама Бин Ладин болон түүний хамсаатан “талибууд” үйлдсэн байх магадлалтай гэж дэлхийн дийлэнх улм орнууд үзэж байна. дээр гарсан хэргээс өмнө 1993 онд дэлхийн худалдааны төвд бөмбөг дэлбэрч байсан нь Осама Бин Ладинтай холбогдолтой болох нь батлагдсан байна.

Осама Бин Ладин худалдааны террорист халдлагыг “Энэ бол бурхан цээрлэл үзүүлж байгаа юм, болдог юм болдгоороо болж байна” гэж мэдэгдсэн нь нэг талаар дээрхи хэргийг үйлдсэнээ хүлээн зөвшөөрч байгаагийн илрэл гэж үзэж болох агаад харин талиб гэдэг нь шашны сурагчид юм. Талибуудын дайчид бол 19-29 насны идэр залуус бөгөөд манайхаар багаасаа хийдэд шавилан суусан банди нар ажээ. Афганистан Орос улстай байлдаж байх үед Пакистан руу дүрэвсэн дүрвэгсэдийн хүүхдүүд одоогийн талибуудын дийлэнх нь байдаг байна.

ХИЛ СУДЛАЛ

Тэд лалын ертөнцөд хамгийн хатуу дэглэм, харгис номлолтой радикал сургуулиудаар хүмүүждэг лалын эртний хууль болох Шариатын хуулийг баримтлах нь талибуудын амьдралын шаардлага бөгөөд “Еврей ба загалмайтнуудын эсрэг жихадын төлөө дэлхийн фронт” гэдэг лалы байгууллагаас гаргасан уриалгад “Америкчууд тэдний холбоотон америк цэрэг энгийн иргэдийг нь хүртэл алж устгаж байх нь лалын шашинтан хүн бүхний үүрэг” гэжээ. Ариун – Моший, Харам – Мошийгоос Америкийн бузар нөлөө арилж лалын шашинтай орон бүхнээс америк цэрэг гарч лал хүн бүр амар тайван амьдрах тэр баг хүртэл тэмцэх ёстой хэмээдэг байна. Энэ бол зөвхөн лалын зарим террорист байгууллагын талаархи жишээ бөгөөд дэлхийн бусад орнуудад (Тува, Индонез...) өөр төрлийн террорист байгууллагууд байсаар байгаа билээ.

Терроризм нт маш олон янзын байдлаар нийгэм, улс оронд илрэн гардаг. Энэхүү илрэн гарч байгаа хор хөнөөлт алан хядах зорилго бүхий үйлдлийг хоёр хэсэгт хуваан үзэж болох юм.

1. Ил терроризм
2. Далд терроризм (биотерроризм)

Ил терроризм бол учруулж байгаа аюул занал, гарсан хохирол нь бидэнд үзэгдэж байдаг албан байгууллага, барилга байгууламжийг сүйтгэх, онгоц барьцаалах, зорчигчдод хүндрэл учруулах, тэднийг барьцаалан сүрдүүлэх зэрэг хэлбэрүүдээр нийтэд ил явагддаг.

Энэ нь айлган сүрдүүлэх зорилгоо хэрэгжүүлж заналхийлэх үндсэн аргатай, ийм тохиолдолд тэд олон хүн цугладаг олон нийтийн Олон улсын шинжтэй объектод хүмүүсийн нүдэн дээр шууд халддаг. Жишээ нь 2001.09.11.-ний АНУ-д болсон хэрэг нь ил терроризмын сонгодог жишээ юм.

Мөн агаарын хөлөг барьцаалах, дэлбэлэх, түүгээр бусад объектыг устгах явдал нэмэгдэж байна. Агаарын хөлөг дээр үйлдэх гэмт хэрэг нь 1960 оны үеэс эхэлжээ. 1970 онд Агаарын тухай гаалийн конвенцийг Европод байгуулж, уг үйлдлийг олон улсын шинжтэй гэмт хэрэг гэж тодорхойлсноос гадна гэмт хэрэгтнүүд эрүүгийн хатуу ял ноогдуулж байх үүргийг оролцогч орнууд өөртөө хүлээсэн байна.

Ийм гэмт хэргийн нийгэмд учруулах хор уршиг нь улс оронд ихээхэн хохирол учруулдаг, зөвхөн нисэх онгоц төдийгүй бас ослын газар дээр байсан хүмүүс амь эрсдэж болзошгүй аюултай байдаг ажээ.

Далд терроризм буюу заримдаа биотерроризм гэгддэг хэлбэр нь мансууруулах бодис наймаалах, садар самууныг сурталчлан дэлгэрүүлэх, хүмүүсийн оюун санаанд нөлөөлөх янз бүрийн нянг телехолбоогоор тараах гэх мэт аргаар явагддаг. Жишээ нь АНУ-ын шуудангийн хэсгүүдээс боомын нян илэрсэн. Монголд ч Дорнод аймгийн Гурванзагал суманд саяхан боомын нян илэрсэн нь далд терроризм манайд ойрхон байгааг харуулж байна. Биотерроризм нь хамгийн өргөн тархалттай нууцлагдмал, хамрах хүрээ өргөн байдгаараа аюултай юм.

Бидний газар зүйн хөрш хоёр гүрэн хоёулаа хар тамхи, мансууруулах бодис хэрэглэх, ДОХ зэрэг нийгмийн онц аюултай үзэгдлүүд гарч байгаа байдлаараа дэлхийд дээгүүрт ордог нь түгшүүр бидэнд ойрхон байгааг илт харуулж байна.


Ер нь терроризмын үр дагавар даяарчлалын замаар Монголд шууд буюу шууд бус нөлөөлнө. Дэлхийн эдийн засаг интеграцид орж, АНУ-д болсон террорист аллагаас шалтгаалан дэлхийн улс орнуудын эдийн засагт нөлөөлж байлаа.

Энэ аллагаас болж Монгол улс НҮБ-аас авах байсан зээлээ авч чадаагүй нь терроризм, өлсгөлөн, халдварт өвчин, дайн дажинаас сэргийлэх зэрэг асуудлыг дэлхийн бүх улс орон хамтран шийдэх гэсэн эрмэлзлэл хүчтэй болж байна.

Иймээс улс орнуудын нийтээр хүлээн зөвшөөрөх ерөнхий зарчим, үнэт зүйлс улам бүр ойр болж энэ чиглэлээрээ гарсан олон улсын конвенц, хууль тогтоомж, дүрэм журмыг улс орон бүр чанд мөрдөн биелүүлэх шаардлага тавигдаж байна гэж үзэж болно.

Ингэхлээр манай орны олон улстай харьцдаг байгууллага, нэгжүүд ялангуяа хилийн албан хаагчид олон улсын эрх зүйн өндөр боловсрол мэдлэгтэй байх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

ХИЛ СУДЛАЛ



Эцэст нь даяарчлал эерэг, сөрөг үр дагаврыг төрүүлж байна.

Эерэг тал нь:

- Нийгэм эдийн засгийн хөгжил дэвшлийг хангах ард олны амьдралын түвшинг дээшлүүлэхэд эерэгээр нөлөөлж байгаа.

- Монгол мэтийн жижиг орнууд төр, улсаа бататган хөгжүүлэх, тусгаар тогтнолоо хамгаалах найдвартай үндэс бий болгох зэрэг ерөнхий асуудлуудыг хэлж болно.

Сөрөг тал нь:

- Жижиг улсууд том гүрэнд уусах магадлалтай жишээ нь социализмын үед бид нэлээд оросжсон бол одоо нэлээд европжих, Англи, Америкийн нөлөөг дагах хандлага ажиглагдаж байна.

Эдгээрээс дараах дүгнэлтийг хийж болно. Дэлхийн улс орнууд даяарчлалын замаар хөгжиж байгаа өнөө үед улс орнуда байнга гарч байгаа терроризмын халдлага Монголын эдийн засаг улс төр гадаад харилцаа зэрэг олон салбарт сөргөөр нөлөөлнө. Тиймээс ийм чиглэлийн гэмт хэргийн үр дагаврыг монголд дэлгэрүүлэхгүйн тулд Монгол улсын хилийн цэрэг, батлан хамгаалах, улсын аюулаас хамгаалх зэрэг байгууллагуудын ажилтнууд уг асуудлыг судалж түүний мөн чанар, илрэх хэлбэр гарч болох хор хөнөөл түүнээс сэргийлэх арга замын талаар гүнзгий мэдэж байх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Үүнийг үндэслэн хилчдэд терроризм түүнээс сэргийлэх асуудлаар сургалт явуулах, ХИДС-ийн сургалтын хөтөлбөрт энэ сэдвийг багтааж ирээдүйн офицер сурган хүмүүжүүлэгчдэд өргөн мэдлэг олгох нь улсын аюулшгүй байдлыг мөн даяарчлалын мөн чанар, үр дагаврыг судлахгүй орхигдуулж болохгүй нь ойлгомжтой.

*ХИДС-ийн эрх зүйн хоёрдугаар дамжааны
оюутан Б.Хоролмаа*